


Бага насны хүүхдийн эгоцентр ярианы талаарх Ж.Пиаже, Л.С.Выготский нарын үзэл баримтлалын ялгаа

Очиржавын Мягмар
Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Одонхүүгийн Мөнхжаргал
Монгол Улсын Их Сургууль (Баруун Бүсийн сургууль)

https://journal.mnier.mn
Санал болгож буй эшлэл:
Мягмар, О., Мөнхжаргал, О. (2026) Бага насны хүүхдийн эгоцентр ярианы талаарх Ж.Пиаже, Л.С.Выготский нарын үзэл баримтлалын ялгаа. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл, 31(1).* https://doi.org/10.56380/mjer.v31.1.4

Differences Between Jean Piaget's and Lev Vygotsky's Views on Egocentric Speech in Young Children

Myagmar Ochirjav
Mongolian National University of Education

Munkhjargal Odonkhuu
National University of Mongolia, Western Regional School

To cite this article:
Myagmar, O., Munkhjargal, O. (2026). Differences Between Jean Piaget's and Lev Vygotsky's Views on Egocentric Speech in Young Children. *Mongolian Journal of Educational Research, 31(1).* https://doi.org/10.56380/mjer.v31.1.4

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.

This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Боловсролын судалгааны Монголын сэтгүүл MJER

2026, Vol. 31, No. 1 https://doi.org/10.56380/mjer.v31.1.4

Бага насны хүүхдийн эгоцентр ярианы талаарх Ж.Пиаже, Л.С.Выготский нарын үзэл баримтлалын ялгаа

Очиржавын Мягмар, Одонхүүгийн Мөнхжаргал

Өгүүллийн мэдээлэл

Түүх:
Хүлээн авсан: 2025.12.26
Засаж сайжруулсан: 2026.10.13
Хэвлэхийг зөвшөөрсөн: 2026.10.26

Түлхүүр үг:
Эгоцентр яриа
Төрөл, үүрэг
Эгоцентр ярианы коэффициент

ХУРААНГУЙ

Ж. Пиаже, Л. С. Выготский нарын хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийн талаарх үзэл баримтлал нь бага насны хүүхдийн сэтгэцийн хөгжлийг тайлбарлах онолын чухал үндэс болдог. Энэхүү судалгааны зорилго нь бага насны хүүхдийн эгоцентр ярианы талаарх хоёр эрдэмтний үзэл баримтлалын ижил болон ялгаатай талыг тодорхойлоход оршино. Судалгаанд баримт бичгийн шинжилгээнд тулгуурласан онолын харьцуулсан аргыг ашиглаж, эгоцентр ярианы үүсэл, мөн чанар, төрөл, үүрэг, хөгжлийн чиг хандлага, арга зүйг харьцуулан шинжилсэн. Үр дүнд тэд эгоцентр ярианы үзэгдлийг хүлээн зөвшөөрсөн боловч түүний сэтгэл зүйн үүрэг, хөгжлийн чиг хандлагыг ялгаатай тайлбарласан байна. Ж. Пиаже эгоцентр ярианы хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн онцлогтой холбон тайлбарлаж, нас нэмэгдэхийн хэрээр ярианд эзлэх жин нь буурна гэж үзсэн. Харин Л. С. Выготский эгоцентр ярианы нийгмийн харилцаанаас үүсэлтэй, хүүхдийн үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулах үүрэгтэй бөгөөд хөгжлийн явцад дотоод ярианд шилждэг гэж тайлбарлажээ. Арга зүйн хувьд Пиаже хүүхдийн ярианы байгалийн нөхцөлд ажигласан бол Выготский туршилтын нөхцөлд судалснаараа ялгаатай байна. Энэхүү харьцуулалт нь хүүхдийн өөртөө чиглэсэн ярианы сэтгэл зүйн үүргийг ойлгох, сургуулийн өмнөх боловсролын практикт хүүхдийн ярианы ажиглан тайлбарлахад онолын ач холбогдолтой юм.

Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:
Одонхүүгийн Мөнхжаргал, Монгол Улсын Их Сургууль (Баруун Бүсийн сургууль),
e-mail: munkhjargal_o@num.edu.mn

Differences Between Jean Piaget's and Lev Vygotsky's Views on Egocentric Speech in Young Children

Myagmar Ochirjav, Munkhjargal Odonkhuu

Article information

Article history:
Received: Dec 26, 2025
Revised: Oct 13, 2026
Accepted: Oct 26, 2026

Keywords:
Egocentric Speech
Types and Functions
Coefficient of Egocentric Speech

ABSTRACT

Jean Piaget's and Lev S. Vygotsky's perspectives on language and cognitive development provide an important theoretical foundation for understanding early childhood development. This study aims to identify the similarities and differences between their views on egocentric speech in young children. Using a comparative theoretical approach based on document analysis, the study examines their original works and relevant literature, focusing on the origins, nature, types, functions, developmental trajectories, and research methods associated with egocentric speech. The findings indicate that although both scholars acknowledged egocentric speech, they differed in their explanations of its psychological functions and development. Piaget associated egocentric speech with cognitive development and argued that its proportion decreases with age. In contrast, Vygotsky viewed it as originating in social interaction, serving to plan and regulate children's activities, and gradually transforming into inner speech. Methodologically, Piaget observed children's everyday speech in natural settings, whereas Vygotsky investigated its functions through experimentally induced difficulties.

This comparison contributes to understanding the psychological functions of children's self-directed speech and provides a theoretical basis for observing and interpreting speech in early childhood education.

This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:
Munkhjargal Odonkhuu, National University of Mongolia (Western Regional School),
e-mail: munkhjargal_o@num.edu.mn

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ суралцагчийн хөгжлийн онцлогт нийцүүлэн конструктивист болон хувилбарт сургалтын онолд суурилсан сургалтын идэвхтэй арга хэрэглэхээр тусгасан (МУЗГ, 2024). Энэ нь бага насны хүүхдийн танин мэдэхүй, хэл, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг онолын үндэслэлтэй судалж, сургалтын арга зүйтэй уялдуулах хэрэгцээг харуулж байна.

Хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийн зүй тогтлыг тайлбарлахад Ж.Пиаже, Л.С.Выготский нарын үзэл баримтлал чухал байр суурь эзэлдэг. Тэдгээрийн онолын нэгэн чухал асуудал нь бага насны хүүхдийн эгоцентр ярианы үүсэл, мөн чанар, үүрэг болон хөгжлийн чиг хандлагыг тайлбарлахтай холбоотой юм. Ж.Пиаже хүүхэд ярьж байх үедээ ямар хэрэгцээгээ хангахыг хүсэж байдаг вэ гэсэн асуултыг дэвшүүлж, үүнийг зөвхөн хэл шинжлэл, логикийн бус, функциональ сэтгэл судлалын үүднээс судлах шаардлагатай гэж үзжээ (Piaget, 1926, p. 1). Түүний “Хүүхдийн хэл ба сэтгэхүй” бүтээл хэвлэгдсэнээс хойш хүүхдийн эгоцентр ярианы талаарх онолын тайлбарыг дэмжсэн болон шүүмжилсэн судалгаанууд хийгдэх болсон.

Эдгээрээс Л.С.Выготскийн үзэл баримтлал онцгой байр суурь эзэлдэг. Тэрээр Пиажегийн судалгааны шинэлэг тал, ач холбогдлыг өндрөөр үнэлсэн хэдий ч эгоцентр ярианы мөн чанар, үүргийн талаарх тайлбарыг туршилт судалгаагаар шалгах шаардлагатай гэж үзсэн (Выготский, 1934, х. 33). Ж.Пиаже хүүхдийн эгоцентр яриаг түүний сэтгэхүйн онцлогийн илрэл гэж тайлбарласан бол Л.С.Выготский уг яриаг хүүхдийн үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулах үүрэгтэй, гадаад ярианаас дотоод ярианд шилжих хөгжлийн завсрын хэлбэр хэмээн үзсэн. Ийнхүү хоёр эрдэмтэн бага насны хүүхдийн эгоцентр яриаг судалсан боловч түүний үүсэл, сэтгэл зүйн үүрэг, нийгмийн шинж болон цаашдын хөгжлийг ялгаатай тайлбарлажээ.

Энэхүү онолын ялгаа нь хүүхдийн эгоцентр яриаг зөвхөн хэл ярианы хөгжлийн нэг илрэл гэж үзэх үү, эсвэл хүүхдийн сэтгэхүй, үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой хөгжлийн чухал механизм гэж ойлгох уу гэсэн асуудлыг дэвшүүлж байна. Түүнчлэн хоёр эрдэмтний судалгааны арга зүй, онолын тайлбарын ялгааг харьцуулан авч үзэх нь хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийн талаарх үзэл баримтлалыг илүү гүнзгий ойлгоход ач холбогдолтой юм. Иймээс тэдгээрийн үзэл баримтлалыг эгоцентр ярианы үүсэл, мөн чанар, төрөл, үүрэг, хөгжлийн чиг хандлага гэсэн үндсэн хэмжээсээр харьцуулан шинжлэх шаардлагатай гэж үзлээ.

Энэхүү өгүүллийн зорилго нь бага насны (2-6 нас) хүүхдийн эгоцентр ярианы талаарх Ж.Пиаже, Л.С.Выготский нарын үзэл баримтлалыг харьцуулан шинжилж, тэдгээрийн ижил болон ялгаатай талыг тодорхойлох, хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийг тайлбарлахад эзлэх онолын ач холбогдлыг тодруулахад оршино. Энэхүү онолын харьцуулалт нь сургуулийн өмнөх насны хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг ойлгох, хүүхдийн хөгжлийн түвшинд нийцсэн сургалтын арга зүйг сонгох, боловсронгуй болгоход онол, арга зүйн үндэслэл болох боломжтой юм.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Бага насны хүүхдийн эгоцентр ярианы талаарх судалгааны онолын үндэс нь Ж.Пиаже, Л.С.Выготский нарын хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийн талаарх үзэл баримтлалтай холбоотой. Тэд хүүхдийн ярианд эгоцентр шинж илэрдгийг хүлээн зөвшөөрсөн боловч түүний үүсэл, сэтгэл зүйн үүрэг, нийгмийн шинж болон хөгжлийн чиг хандлагыг ялгаатай тайлбарласан байдаг (Piaget, 1926; Выготский, 1934). Эдгээр ялгаа нь хүүхдийн яриаг танин мэдэхүйн хөгжлийн илрэл гэж үзэх, эсвэл танин мэдэхүйн үйл ажиллагааг зохицуулах хэрэгсэл гэж тайлбарлах онолын маргааны үндэс болжээ.

Эгоцентр ярианы мөн чанар, үүсэл

Ж.Пиаже хүүхдийн өдөр тутмын яриаг ажиглан судалж, эгоцентр ярианы онцлогийг харилцан ярилцагчийн байр суурийг харгалзан үзэхгүйгээр өөрийн үйл ажиллагаа, бодол санааг илэрхийлж байгаатай холбон тайлбарласан (Piaget, 1926). Харин Л.С.Выготский хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийг соёл-түүхийн онолын хүрээнд авч үзэж, эгоцентр яриа нь нийгмийн харилцаанаас үүсэлтэй бөгөөд хөгжлийн явцад дотоод ярианд шилждэг гэж үзжээ (Выготский, 1934). Энэхүү тайлбар нь сэтгэцийн дээд үйл ажиллагаа эхлээд хүмүүс хоорондын харилцаанд илэрч, улмаар

дотогшиж, хувь хүний сэтгэцийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн болдог гэсэн онолын үндэслэлтэй холбоотой юм.

Хоёр эрдэмтний үзэл баримтлалын ялгаа нь судалгааны арга зүйд мөн илэрдэг. Пиаже хүүхдийн өдөр тутмын яриаг байгалийн нөхцөлд ажигласан бол Выготский хүүхдийн үйл ажиллагаанд зориудаар бэрхшээл үүсгэж, эгоцентр ярианы үүргийг туршилтаар тодруулахыг зорьжээ. Тухайлбал, зураг зурахад шаардлагатай хэрэглэгдэхүүнийг зориудаар дутуу байлгах үед хүүхэд өөрийн үйлдлийг үгээр зохицуулахыг оролдож байгааг ажигласан байна (Выготский, 1934). Энэ нь эгоцентр яриаг зөвхөн үйл ажиллагааг дагалдах үзэгдэл бус, асуудал шийдвэрлэх үйл явцтай холбоотой гэж тайлбарлах үндэслэл болжээ.

Эгоцентр ярианы үүрэг, хөгжлийн чиг хандлага

Пиаже эгоцентр яриаг хүүхдийн сэтгэхүйн эгоцентр шинжтэй холбон тайлбарлаж, нас нэмэгдэхийн хэрээр бусдын байр суурийг харгалзан үзэх чадвар хөгжиж, ярианы нийгэмшсэн шинж нэмэгдэнэ гэж үзсэн. Харин Выготский эгоцентр яриа нь гадаад ярианаас дотоод яриand шилжих завсрын хэлбэр бөгөөд хүүхдийн үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулах үүрэгтэй гэж тайлбарласан (Piaget, 1926; Выготский, 1934). Пашукова (2016) эдгээр үзэл баримтлалын ялгааг авч үзэхдээ эгоцентр ярианы үүсэл, үүрэг болон хөгжлийн чиглэлийг тайлбарлах онолын үндэслэлүүдийг харьцуулсан байна. Түүнчлэн Кравец (2015) хүүхдийн ярианы онтогенез хөгжлийг тайлбарлахад Пиаже, Выготский нарын үзэл баримтлалын зөрүүг авч үзсэн нь эгоцентр ярианы хөгжлийн чиглэлийн талаарх онолын маргааныг тодруулахад ач холбогдолтой юм.

Орчин үеийн судалгаанд хүүхдийн өөртөө чиглэсэн яриа болон дотоод ярианы хөгжлийг танин мэдэхүйн үйл ажиллагаа, өөрийгөө зохицуулах чадвартай холбон судалж байна. Alderson-Day болон Fernyhough (2015) дотоод ярианы хөгжил, танин мэдэхүйн үүрэг, сэтгэл зүйн онцлогийг нэгтгэн авч үзсэн бол Davis нар (2013) хүүхдийн өөртөө чиглэсэн ярианы хувь хүний ялгааг төсөөллийн найзтай байх онцлогтой холбон судалжээ. Эдгээр судалгаа нь өөртөө чиглэсэн яриаг хүүхдийн хөгжлийн явцад илэрдэг, танин мэдэхүйн үйл ажиллагаатай холбоотой үзэгдэл болохыг судлахад ач холбогдолтой боловч Пиаже, Выготский нарын онолын бүх маргааныг шууд шийдвэрлэсэн гэж үзэх боломжгүй юм.

Нийгмийн орчин ба онолын тайлбарын талаарх судалгаа

Хүүхдийн эгоцентр ярианы хөгжилд нийгмийн харилцааны гүйцэтгэх үүрэг нь хоёр онолын харьцуулалтын чухал асуудал юм. Выготскийн соёл-түүхийн онолд хэл, сэтгэхүйн хөгжил нь нийгмийн харилцаа, хамтын үйл ажиллагаатай салшгүй холбоотой гэж үздэг (Выготский, 1934). Гэхдээ Пиаже нийгмийн хүчин зүйлсийн үүргийг бүрэн үгүйсгэсэн гэж тайлбарлах нь өрөөсгөл болохыг Lourenço болон Machado (1996) тэмдэглэжээ. Тэд Пиажегийн онолд хандсан нийтлэг арван шүүмжлэлийг авч үзэж, түүний үзэл баримтлалыг хөгжлийн үе шат, онолын агуулга, түүхэн нөхцөлтэй нь холбон тайлбарлах шаардлагатайг онцолсон байна. Иймээс хоёр онолын ялгааг нийгмийн хүчин зүйлийг хүлээн зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн гэсэн энгийн эсрэгцүүллээр бус, нийгмийн харилцаа ба танин мэдэхүйн хөгжлийн харилцан хамаарлыг хэрхэн тайлбарлаж байгаагаар нь авч үзэх нь зүйтэй юм.

Онолын үзэл баримтлалын орчин үеийн ач холбогдол

Пиаже, Выготский нарын үзэл баримтлал нь сургуулийн өмнөх боловсролын онол, арга зүйн судалгаанд чухал байр суурь эзэлсээр байна. Veraksa болон Pramling Samuelsson нар (2022) эдгээр онолыг орчин үед сургуулийн өмнөх боловсролын түвшинд авч үзэж, хүүхдийн хөгжил, сургалтын үйл явцыг тайлбарлахад онол хоорондын харьцуулалт чухал болохыг онцолжээ. Нео нар (2011) Пиажегийн эгоцентризмын ойлголтыг хэл суралцах үйл явцтай холбон авч үзсэн бол Alharbi (2022) Пиаже, Выготский нарын онолд тулгуурлан багшийн үйл ажиллагаа болон хүүхдийн тоглоомын харилцан хамаарлыг судалсан байна. Мөн Zhao (2022) Пиажегийн танин мэдэхүйн хөгжлийн онолыг бага насны хүүхдийн хоёр дахь хэл эзэмшихэд зориулсан зурагт номын агуулгыг үнэлэхтэй холбон авч үзжээ. Эдгээр бүтээл нь сонгодог онолыг сургалтын агуулга, хэрэглэгдэхүүн болон багшийн арга зүйтэй холбон судалж болохыг харуулж байгаа боловч эгоцентр ярианы сэтгэл зүйн үүргийг шууд судалсан үр дүн биш юм.

Манай улсад хэвлэгдсэн хүүхдийн хөгжлийн сэтгэл судлалын ном, сурах бичгүүдэд хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийн талаарх сонгодог онолуудыг авч үзсэн байдаг (Мягмар, 2010, 2016). Эдгээр бүтээл нь хүүхдийн сэтгэцийн хөгжлийн онолын мэдлэгийг сургалт, судалгаанд ашиглахад ач холбогдолтой. Харин энэхүү өгүүлэлд эгоцентр ярианы үүсэл, мөн чанар, үүрэг болон хөгжлийн чиг хандлагыг Пиаже, Выготский нарын анхдагч бүтээлүүдэд тулгуурлан харьцуулж байгаагаараа онолын тодорхой асуудалд төвлөрч байна.

Өмнөх судалгаануудыг авч үзэхэд, нэгдүгээрт, бага насны хүүхдийн эгоцентр яриа нь хэл, сэтгэхүйн хөгжлийн чухал үзэгдэл болохыг сонгодог онолууд болон дараагийн судалгаануудад авч үзсэн байна. Хоёрдугаарт, эгоцентр ярианы үүсэл, нийгмийн шинж, сэтгэл зүйн үүрэг, хөгжлийн чиг хандлагыг тайлбарлахад онолын ялгаа хэвээр байна. Гуравдугаарт, орчин үеийн судалгаанд хүүхдийн өөртөө чиглэсэн яриа, дотоод яриа, танин мэдэхүйн зохицуулалтын холбоог судалж байгаа боловч сонгодог онолын үзэл баримтлал, судалгааны арга зүй болон боловсролын практикт холбогдох тайлбарыг ялган авч үзэх шаардлагатай байна.

Иймд энэхүү өгүүлэлд Ж.Пиаже, Л.С.Выготский нарын анхдагч бүтээл болон холбогдох судалгаанд тулгуурлан эгоцентр ярианы үүсэл, мөн чанар, төрөл, үүрэг, хөгжлийн чиг хандлага, судалгааны арга зүйн ижил болон ялгаатай талыг харьцуулан шинжилж, тэдгээрийн хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийг тайлбарлах онолын ач холбогдлыг тодруулахыг зорилоо.

АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаанд баримт бичгийн шинжилгээнд тулгуурласан онолын харьцуулсан судалгааны арга зүйг ашиглав. Судалгааны хүрээнд харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргаар генетик эпистемологи болон соёл-түүхийн онолын чиглэлд хамаарах анхдагч бүтээлүүд, тэдгээрийг тайлбарласан эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны материалуудыг авч үзсэн.

Эх сурвалжийн сонголт.

Судалгааны анхдагч эх сурвалжаар Ж.Пиажегийн The Language and Thought of the Child (Piaget, 1926), Л.С.Выготскийн Мышление и речь (Выготский, 1934) бүтээлүүдийг сонгон ашиглав. Эдгээр бүтээлд бага насны хүүхдийн эгоцентр ярианы үүсэл, мөн чанар, үүрэг, хөгжлийн чиг хандлага болон тэдгээрийг судалсан ажиглалт, туршилтын арга зүйг анхдагч байдлаар тайлбарласан тул онолын харьцуулалтын үндсэн эх сурвалж болгосон. Хоёрдогч эх сурвалжид эдгээр онолын үзэл баримтлалыг тайлбарласан, харьцуулсан, шүүмжлэлтэй авч үзсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны болон онолын бүтээлүүдийг хамруулав.

Эх сурвалжийг сонгохдоо бага насны хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжил, эгоцентр ярианы онцлог, сэтгэл зүйн үүрэг, нийгмийн шинж болон хөгжлийн талаарх Пиаже, Выготский нарын онол, туршилт судалгаатай агуулгын хувьд шууд холбоотой байхыг үндсэн шалгуур болгов. Мөн хоёр онолын ялгааг тайлбарласан болон тэдгээрийн боловсролын практикт холбогдох ач холбогдлыг авч үзсэн бүтээлүүдийг харгалзан үзсэн.

Харьцуулсан шинжилгээ.

Сонгосон эх сурвалжуудад тулгуурлан Пиаже, Выготский нарын үзэл баримтлалыг эгоцентр ярианы 1. үүсэл, 2. мөн чанар ба нийгмийн шинж, 3. төрөл, ангилал, 4. сэтгэл зүйн үүрэг, 5. хөгжлийн чиг хандлага, 6. судалгааны арга зүй гэсэн үндсэн хэмжээсээр харьцуулан авч үзэв. Ингэхдээ хоёр эрдэмтний анхдагч бүтээлд тусгагдсан онолын тайлбар, ажиглалт, туршилтын үр дүн, дүгнэлтийг харьцуулж, ижил болон ялгаатай талыг тодорхойлохыг зорив.

Шинжилгээний хүрээнд эхлээд анхдагч бүтээлүүд дэх эгоцентр ярианы талаарх үндсэн ойлголт, тайлбарыг тодруулж, дараа нь тэдгээрийг хоёрдогч эх сурвалжид хэрхэн тайлбарласан, дэмжсэн, шүүмжилсэн байдлыг авч үзсэн. Улмаар харьцуулалтын хэмжээс тус бүрээр онолын ижил болон ялгаатай талыг нэгтгэн дүгнэж, бага насны хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийг ойлгох болон сургуулийн өмнөх боловсролын сургалтын арга зүйд холбогдох ач холбогдлыг тайлбарлав.

Судалгааны үе шат.

Судалгааг 2024-2026 онд үе шаттайгаар гүйцэтгэсэн. Нэгдүгээрт, Ж.Пиажегийн The Language and Thought of the Child (Piaget, 1926), Л.С.Выготскийн Мышление и речь (Выготский, 1934)

бүтээлүүдийг судалж, эгоцентр ярианы талаарх онолын үндсэн ойлголт, тайлбаруудыг тодруулан, мэргэжлийн тэнхимийн өргөтгөсөн семинарт хэлэлцүүлсэн (2024-2025 он). Хоёрдугаарт, хоёр эрдэмтний үзэл баримтлалтай холбоотой хоёрдогч эх сурвалжуудыг тоймлон судалж, онолын тайлбар, судалгааны үр дүнг харьцуулан шинжилсэн (2026 он). Гуравдугаарт, харьцуулсан шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, бага насны хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийг ойлгох болон сургуулийн өмнөх боловсролын сургалтын арга зүйд холбогдох дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан (2026 он).

ҮР ДҮН

Пиаже хүүхдийн хэл, ярианы хөгжлийг судалсан баримтуудыг шинжлэн дүгнээд хүүхдийн яриаг үүргээр нь хэд хэдэн төрөл болгон ангилсан (Зураг 1).



Зураг 1. Хүүхдийн хэл ярианы үүргийн ангилал

Дээрх зурагт байгаа эгоцентр ба нийгэмшсэн яриаг Пиаже дотор нь хэд хэдэн дэд хэсэгт ангилан төрөлжүүлсэн (Piaget, 1926). (Хүснэгт 1, 2, 3).

Хүснэгт 1. Хүүхдийн ярианы төрлүүд

Эгоцентр ярианы төрлүүд	Нийгэмшсэн ярианы төрлүүд
Цуурайлан давтах яриа *(Repetition or echolalia)*	Нийцүүлсэн мэдээлэл *(Adapted information)*
Өөртэйгөө ярих яриа *(Monologue)*	Шүүмжлэл ба тохуурхал *(Criticism and derision)*
Хоёрлосон буюу хуурамч хамтын яриа *(Dual or collective monologue; pseudoconversation)*	Тушаал, хүсэлт, сүрдүүлэг *(Commands, requests and threats)*
	Асуулт *(Questions)*
	Хариулт *(Answers)*


Хүснэгт 2. Эгоцентр ярианы төрлүүд, тэдгээрийн онцлог

Эгоцентр ярианы төрлүүд		
Цуурайлан давтах яриа	Өөртэйгөө ярих яриа	Хоёрлосон буюу хуурамч хамтын яриа
Хүүхэд хэн нэгэн рүү хандах болон ямар нэгэн утга илэрхийлсэн үг хэлье гэсэн санаагүйгээр зөвхөн л таашаал авахын тулд үг, өгүүлбэрийг өөртөө зориулан давтаж хэлэх үзэгдэл. Энэ бол ямар нэгэн нийгмийн утга агуулдаггүй, хүүхдийн шулганаанаас үлдсэн үлдэгдэл.	Монолог -*monologos* (monos+ logos: ганц яриа гэсэн грек үгнээс гаралтай), ганцаараа ярих гэсэн утгыг илэрхийлдэг гэж Пиаже үзжээ. Хүүхэд хэнд ч хандахгүйгээр сонсогдохуйц сэтгэж байгаа мэтээр өөрөө өөртэйгөө ярих яриа.	Тодорхой утга санааг харилцан солилцохгүйгээр өөр хоорондоо ярилцаж байгаа мэтээр өөрөө өөртэйгөө ярих яриа: нэгнийх нь хэлж байгаа өгүүлбэр нөгөө хүүхдийнхтэй холбоогүй байдаг. Үүнийг мөн “Хуурамч харилцан яриа” гэж нэрлэдэг.
Нийтлэг онцлог: Ярианаас авах таашаал ханамжийг илэрхийлэх, хүүхдийн үйлдлийг дагалдан хэмнэлжүүлэх үүрэгтэй. Ийм яриа нь тухайлан хэн нэгэн рүү хандаагүй байх бөгөөд тохиолдлоор хэн хүн ярианд татагдан орж ирвэл түүнд нийцүүлэн ярих оролдлого хийдэггүй.		

Хүснэгт 3. Нийгмийн ярианы төрлүүд, тэдгээрийн онцлог

Нийгмийн ярианы төрлүүд		
Нийцсэн мэдээлэл (Adapted information)	Шүүмжлэл ба тохуурхал (Critisism and derision)	Нийгмийн ярианы бусад төрлүүд
Пиажегийн онол дахь хүүхдийн нийгмийн ярианы онцлогийг тодорхойлох нэг үзүүлэлт: хүүхэд сонсогчийнхоо үзэл санааг хүлээн зөвшөөрч байгаа үеийн мэдээлэл бөгөөд сонсогчоо зориуд сонгосон байдаг.	Шүүмжлэлд бусдын ажил, зан үйлийн талаарх бүхий л сануулга багтдаг. Шүүмжлэл нийцүүлсэн мэдээлэлтэй адил бусдад чиглэгддэг, тохуурхал нь оюун ухааны гэхээсээ илүү сэтгэл хөдлөлийн шинжтэй, хүүхэд давуу талаа харуулан, бусдыг дутуу үнэлэх гэсэн байдлын илрэл.	*Тушаал, хүсэлт, сүрдүүлэг:* Ярианы эдгээр төрлүүдэд нэг хүүхдээс нөгөөдөө үзүүлж буй нөлөөлөл илэрхий харагддаг *Асуулт:* Хүүхдүүдийн бие биедээ тавьж байгаа асуултын ихэнх нь хариулт шаардсан байсан тул нийгэмшсэн ярианд хамруулсан гэж Пиаже бичжээ. *Хариулт:* Энд бодит асуултуудад (асуултын тэмдэг бүхий) болон тушаалд өгч байгаа хариулт орно. Гэхдээ эдгээрийг ярианыхаа явцад өгч байгаа хариулт болон сануулгатай (эдгээр нь хариулт биш, харин “мэдээлэлд харьяалагдана) харьцуулж болохгүй гэжээ.
Нийтлэг онцлог: Хүүхэд сонсогчийнхоо сонирхлыг татахуйц, үйл ажиллагаанд нь нөлөөлөх ямар нэг зүйлийг түүнд хэлэх, маргалдах, түүгээр ч барахгүй нийтлэг зорилгын төлөө хамтран ажиллах зэргээр бусадтай санал бодлоо жинхэнээсээ солилцдог		

Туршилтаар цуглуулсан мэдээлэлдээ үндэслэн Л.С.Выготский “...Бид үүргийн хувьд эгоцентр яриа нь дотоод яриатай төстэй оюуны үүргийг гүйцэтгэдэг гэдгийг олж илрүүлсэн; харин бүтцийн хувьд дотоод ярианд дөхөж очиж байгааг олж илрүүлсэн; түүнчлэн генетикийн хувьд... сургуулийн насны босго үе бол эгоцентр яриа мөхөж устах бус харин дотоод яриа болон өрнөх үе юм” гэж дүгнэсэн (Выготский, 1934, х. 280). Үүнээс үзвэл хүүхдийн эгоцентр ярианы бүтэц, үүргийн талаарх Выготскийн үзэл баримтлалын Пиажегийнхаас ялгагдах гол ялгаа бол хүүхдийн ярианы энэхүү өвөрмөц төрлийг гадаад ярианаас дотоод яриа болон хувирах үйл явцтай холбон авч үзсэнд оршдог. Гэхдээ эгоцентр яриаг дотоод яриатай бүрэн адилтгаагүй, нийгмийн (бусад руу, гадагш чиглэсэн гадаад) ярианаас харин түүн рүү шилжиж буй завсын яриа гэж үзэж буй нь илт харагддаг.



Зураг 2. Эгоцентр ярианы завсрын байр суурь (Л.С. Выготскийн загвараар)

Хүүхдийн нас ахих тусам эгоцентр ярианы эзлэх жин буурдаг уу, эсвэл өсдөг үү гэсэн асуултад энэ хоёр эрдэмтэн эсрэг, тэсрэг хариулт өгдөг. Пиаже бүтээлийнхээ “Эгоцентризмийн хэмжилт” хэсэгт энэ талаар тодорхой тайлбарласан байдаг (Piaget, 1926). Тэрээр хүүхдийн эгоцентр яриаг (эя) нийт чөлөөт ярианд (чөлөөт яриа) харьцуулсан харьцаагаар эгоцентр ярианы коэффициентийг тооцоолсон. Пиаже өөрөө нэг сарын турш даган судалсан хоёр хүүгийн (Лев ба Пи) эгоцентр ярианы коэффициентийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

$$\frac{\text{эя}}{\text{чя}} = 0.47\textit{(Лев)}. \qquad \frac{\text{эя}}{\text{чя}} = 0.43\textit{(Пи)}$$

Эгоцентр ярианы бүлэгт бидний өмнө авч үзсэн ангиллуудын эхний гурав нь болох цуурайлан давтах яриа, өөртэйгөө ярих яриа, хуурамч хамтын яриа багтдаг.

Пиажегийн үзэж байгаагаар 7-8 орчим насны үеэс хүүхдэд бусадтай ажиллах хүсэл илэрч эхэлдэг бөгөөд яг энэ үеэс эгоцентр ярианы ач холбогдол буурч эхэлдэг. Тэрээр энэхүү таамаглалаа

батлахын тулд 6 настай эгэоцентр ярианых нь коэффициентийг тодорхойлж байсан хүүхдүүдийг 7-8 нас хүрснийх нь дараа давтан тодорхойлох хэрэгтэй гэж үзсэн. “Энэ бол бидний судалгааны шинэ зорилго. Иймшинэ судалгааг Бергер хийсэн” (Piaget, 1926, p. 42) гэжээ. Тэдний анх судалсан хоёр хүүгийн нэг Левийг долоон наснаасаа хэдхэн сар өнгөрч байхад нь өмнөхтэй нь ижил нөхцөлд хэдэн сараар дагалдан судалж хэлсэн 600 гаруй үг, өгүүлбэрийг нь тэмдэглэж үзээд түүний эгоцентризмын коэффициент нь 0.27 (өмнө нь 0.47 байсан) хүртэл буурсныг тогтоожээ. Энэ үр дүнг Пиаже хүүхдийн санаа бодлоо илэрхийлэх чадвартай холбон авч үзээд “Бидэнд хангалттай харьцуулалт хийх материал дутмаг байгаа хэдий ч Майсон дес Петитст хийсэн өдөр тутмын ажиглалтдаа тулгуурлан 7-8 наснаасаа (тухайлбал, эгоцентр яриа 25 хувийг эзлэх болсон үеэс) эхлэн хүүхдүүд санаа бодлоо илэрхийлж эхэлдэг гэж үзэх боломжтой. Энэ нь Левийг ажигласан ажиглалтаар ч нотлогдож байна” (Piaget, 1926, p. 42) гэж дүгнэсэн.

Л.С.Выготский хүүхдийн эгоцентр яриа устаж алга болж байгаа бус, харин дотоод ярианд шилжиж, буурч устах биш өсөх чиглэлээр хөгждөг гэж үзжээ. (Выготский, 1934, х. 282).

Эгоцентр ярианы үүсэл, хүүхдийн хэл сэтгэхүйн хөгжлийн холбоо, хамааралтай холбоотой харьцуулалт нь Пиаже, Выготский нарын дэг сургуулиудын ялгаа, сэтгэцийн хөгжлийн хууль, зүй тогтолтой холбоотой, гүн ухаан, сэтгэц хэл шинжлэл, хэл сэтгэхүйн талаарх нейролингивистик загвар зэрэг нарийн нийлмэл олон асуудлыг давхар хөндөх учраас энэхүү өгүүллийн хүрээнд авч үзээгүй болно.

Хүснэгт 4. Бага насны хүүхдийн эгоцентр ярианы талаарх Ж.Пиаже, Л.С.Выготский нарын үзэл баримтлалын ялгаа

Ялгааг илэрхийлэх үзүүлэлтүүд	Л.С.Выготский	Ж.Пиаже
Эгоцентр ярианы онцлог	Эгоцентр яриа бол сэтгэл зүйн үүргийнхээ хувьд дотоод яриа, бүтцийн хувьд гадаад яриаг илэрхийлдэг бөгөөд цаашдаа дотоод яриа болон хувирах тавилантай яриа	Хүүхэд зөвхөн өөртэйгээ ярьж байгаа, бусдад хандаж байгаа мэт атлаа цаад хүнийхээ байр суурийг үл харгалзан ярих яриа. Түүний дэргэдэх хүн зөвхөн “үзэгчийн” төдий үүрэг гүйцэтгэдэг.
Эгоцентр ярианы үүрэг	Дотоод яриатай төстэй оюуны *үүргийг* гүйцэтгэдэг	Өөрийнх нь үйл ажиллагааг дагалдан бэхжүүлэх, таашаал авах үүрэгтэй.
Эгоцентр ярианы бүтэц	*Бүтцийн* хувьд дотоод ярианд дөхөж очдог (үгийг нэг бүрчлэн тоочих бус, хураангуй, зүүвэрлэн хураангуйлсан).	Бүтцийн хувьд 3 төрөлтэй: цуурайлан давтах, өөртэйгээ ярих (монолог), хуурамч хамтын яриа
Онтогенез хөгжилд эзлэх байр суурь	Сургуулийн насны босго үе бол (тэр үеийн 7, 8 нас) эгоцентр яриа мөхөж устах бус харин дотоод яриа болон өрнөх үе юм.	7-8 орчим наснаас эхлэн эгоцентр ярианы эзлэх жин буурч эхэлдэг.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү онолын харьцуулсан шинжилгээнээс үзэхэд Ж.Пиаже, Л.С.Выготский нар бага насны хүүхдийн ярианд эгоцентр шинж илэрдэгийг ажиглалт, туршилтын судалгаагаар тодорхойлсон боловч түүний үүсэл, сэтгэл зүйн үүрэг, хөгжлийн чиг хандлагыг ялгаатай тайлбарласан байна. Эдгээр ялгаа нь хүүхдийн эгоцентр яриаг зөвхөн насны онцлогийн илрэл гэж үзэх, эсвэл хүүхдийн үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулахад оролцдог хөгжлийн чухал хэрэгсэл гэж ойлгох асуудалтай холбоотой юм. Иймээс хоёр онолыг харилцан үгүйсгэсэн байр суурь гэж үзэхээс илүүтэй хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийг өөр өөр талаас тайлбарласан үзэл баримтлал гэж авч үзэх нь зүйтэй.

Пиаже хүүхдийн эгоцентр яриаг бусдын байр суурийг харгалзан үзэх чадварын хөгжилтэй холбон тайлбарласан бол Выготский уг ярианы үйл ажиллагааг зохицуулах үүргийг онцолсон (Piaget, 1926; Выготский, 1934). Энэхүү ялгаа нь хүүхдийн өөртөө чиглэсэн яриаг ажиглахдаа зөвхөн бусадтай харилцаж байгаа эсэхээр нь үнэлэх бус, тухайн яриа хүүхдийн гүйцэтгэж буй үйл ажиллагаатай хэрхэн холбогдож байгааг анхаарах шаардлагатайг харуулж байна. Орчин үеийн судалгаанд дотоод ярианы хөгжил, танин мэдэхүйн үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг авч үзсэн нь Выготскийн дэвшүүлсэн асуудлыг цаашид судлах онолын үндэслэл болж байна (Alderson-Day & Fernyhough,

2015). Гэхдээ дотоод ярианы талаарх судалгааны үр дүнг бага насны хүүхдийн эгоцентр ярианы бүх хэлбэрт шууд хамааруулан тайлбарлах боломжгүй юм.

Хоёр эрдэмтний онолын ялгааг тайлбарлахдаа тэдгээрийн судалгааны арга зүйг харгалзан үзэх нь чухал. Пиаже хүүхдийн өдөр тутмын яриаг байгалийн нөхцөлд ажиглаж, түүний илрэх хэлбэрийг ангилан тодорхойлсон бол Выготский хүүхдийн үйл ажиллагаанд зориудаар бэрхшээл үүсгэх замаар эгоцентр ярианы сэтгэл зүйн үүргийг тодруулахыг зорьжээ. Иймээс тэдгээрийн дүгнэлтийн ялгаа нь зөвхөн онолын байр сууринаас бус, судалгаанд тавьсан асуулт, ажигласан нөхцөл, хэрэглэсэн аргаас хамаарч байгааг анхаарах шаардлагатай. Пиажегийн онолд хандсан шүүмжлэлүүдийг авч үзсэн Lourenço болон Machado (1996) түүний үзэл баримтлалыг анхны агуулга, хөгжлийн үе шат болон судалгааны нөхцөлтэй нь холбон тайлбарлахын ач холбогдлыг онцолсон нь энэхүү харьцуулсан шинжилгээний арга зүйн байр суурьтай нийцэж байна.

Пиаже, Выготский нарын онолын харилцааг зөвхөн санал зөрөлдөөнөөр хязгаарлан тайлбарлах нь учир дутагдалтай юм. Пиаже Выготскийн шүүмжлэлд өгсөн хариу тайлбартаа эгоцентр ярианы хөгжлийн чиг хандлага, түүнийг хүндрүүлсэн нөхцөлд туршилтаар судалсан арга зүйг нь өндрөөр үнэлж, эгоцентр яриа дотоод ярианы хөгжлийн тулгуур болох тухай таамаглалыг дэмжсэн байдаг (Жан Пиаже, 2010). Үүний нэгэн адил Выготский Пиажегийн онолын зарим тайлбарт шүүмжлэлтэй хандсан боловч түүний боловсруулсан клиник аргыг хүүхдийн сэтгэхүйн нарийн төвөгтэй бүтэц, хөгжлийг судлахад чухал ач холбогдолтой гэж үнэлжээ (Выготский, 1934). Энэ нь хоёр эрдэмтний онолын маргааныг харилцан шүүмжилж, судалгааны шинэ асуудал дэвшүүлсэн шинжлэх ухааны хэлэлцүүлэг гэж ойлгох үндэслэл болж байна.

Сургуулийн өмнөх боловсролын практикт хэрэглэх боломж

Харьцуулсан шинжилгээний үр дүн нь бага насны хүүхдийн өөртөө чиглэсэн яриаг багш хэрхэн ажиглах, ойлгох, сургалтын үйл ажиллагаанд харгалзан үзэхэд тодорхой ач холбогдолтой юм. Тухайлбал, хүүхэд зураг зурахдаа “Голыг цэнхэрээр будах хэрэгтэй, гэхдээ надад цэнхэр будаг алга. Би бороор будъя” гэх мэтээр өөртөө ярьж байвал энэ нь зөвхөн бусдад мэдээлэл дамжуулах зорилготой яриа бус, өөрийн үйлдлийг төлөвлөж, тулгарсан асуудлыг шийдвэрлэх оролдлогын илрэл байж болно. Иймээс нөхцөлд багш хүүхдийн яриаг тасалдуулах, шууд засахын оронд түүний хийж буй үйл ажиллагаатай холбон ажиглаж, шаардлагатай үед “Өөр ямар өнгө ашиглаж болох вэ?, Яагаад энэ өнгийг сонгосон бэ?” зэрэг асуултаар бодол санаагаа тайлбарлах боломж олгох нь зүйтэй.

Мөн хүүхэд багшийн асуултад шууд хариулахгүйгээр өөрийн хийж буй үйл ажиллагааны талаар ярьж эхэлбэл үүнийг шууд дуулгаваргүй байдал, анхааралгүй байдал гэж дүгнэхээс зайлсхийх хэрэгтэй. Харин тухайн яриа хүүхдийн өмнө нь гүйцэтгэж байсан үйл ажиллагаатай холбоотой эсэх, өөрийн үйлдлийг тайлбарлаж байгаа эсэхийг ажиглан тодруулах нь чухал. Энэ нь хүүхдийн ярианы агуулга, нөхцөл, үүргийг харгалзан үзэх боломжийг бүрдүүлнэ.

Түүнчлэн цэцэрлэгийн 4-5 настай хүүхдүүд хамтран тоглох, бүтээл хийх үедээ нэг орчинд зэрэгцэн ажиллаж байгаа боловч өөр өөрийн үйл ажиллагааны талаар ярьж болох юм. Ийм тохиолдолд багш хүүхдүүдийн яриа бусдад хандсан эсэх, харилцан ойлголцож байгаа эсэх, эсвэл өөрийн үйлдлийг дагалдан илэрч байгаа эсэхийг ажиглаж болно. Үүний зэрэгцээ хамтын үйл ажиллагааны явцад хүүхдүүд бие биеийнхээ санааг сонсох, өөрийн хийж буй зүйлийг тайлбарлах, хамтран шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй. Энэ нь Пиажегийн онолд онцолсон бусдын байр суурийг харгалзан үзэх чадвар болон Выготскийн онолд чухалчилсан нийгмийн харилцаа, хамтын үйл ажиллагааны ач холбогдлыг сургалтын практикт уялдуулах боломжтой юм.

Бага насны хүүхдийн өөртөө чиглэсэн яриа нь сургалтын явцад заавал таслан зогсоох шаардлагатай үйлдэл биш бөгөөд түүний нөхцөл, үүргийг ойлгох нь чухал. Гэхдээ үүнээс хүүхдийн бүх чанга яриа, шуугиан нь эгоцентр ярианы илрэл гэж дүгнэж болохгүй. Тухайлбал, хүүхдүүдийн дуу чимээг зохицуулахдаа багш өөрөө намуухан ярих, дуу аялах, тоглоомын аргаар анхаарлыг төвлөрүүлэх зэрэг аргыг хэрэглэж болох боловч эдгээр аргын үр нөлөөг эгоцентр ярианы онолоор дангаар нь тайлбарлах боломжгүй юм. Харин хүүхдийн хөгжлийн онцлог, тухайн үйл ажиллагааны зорилго, орчны нөхцөлтэй уялдуулан хэрэглэх нь зүйтэй.

Выготскийн онолд хэл, сэтгэхүйн хөгжил нь нийгмийн харилцаа, хамтын үйл ажиллагаанаас дотоод оюуны үйл ажиллагаанд шилжих үйл явцтай холбоотой гэж үздэг (Выготский, 1934). Энэ байр

сууринаас авч үзвэл хүүхдийн гэр бүл, цэцэрлэгийн орчин дахь харилцааны боломж болон цахим хэрэглээний нөхцөл нь цаашид судлах шаардлагатай асуудал юм. Тухайлбал, дэлгэцийн хэрэглээний үед хүүхэд насанд хүрэгчидтэй хэр зэрэг харилцаж байгаа, өөрийн үйл ажиллагааг үгээр тайлбарлах боломжтой байгаа эсэх, хамтын тоглоом болон асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгааг судалж болно. Гэхдээ энэхүү өгүүлэлд цахим хэрэглээний нөлөөг шууд судлаагүй тул хүүхдийн хэл ярианы хөгжлийн өөрчлөлтийг дэлгэцийн хэрэглээнээс шалтгаалсан гэж дүгнэх үндэслэлгүй юм.

Пиаже, Выготский нарын үзэл баримтлал нь орчин үеийн сургуулийн өмнөх боловсролын онол, арга зүйн судалгаанд ач холбогдолтой хэвээр байгааг Veraksa болон Pramling Samuelsson нар (2022) тэмдэглэсэн. Мөн Alharbi (2022) хүүхдийн тоглоом, багшийн үйл ажиллагааг хоёр онолын үүднээс авч үзсэн нь хүүхдийн хөгжлийн онолыг сургалтын практиктай холбон тайлбарлах боломжийг харуулж байна. Иймээс хүүхдийн эгоцентр ярианы талаарх онолын ялгааг багшийн ажиглалт, сургалтын харилцаа, хүүхдийн бие даасан болон хамтын үйл ажиллагаатай уялдуулан авч үзэх нь зүйтэй.

Судалгааны хязгаарлалт ба цаашдын чиглэл

Энэхүү судалгаа нь Пиаже, Выготский нарын анхдагч бүтээл болон холбогдох хоёрдогч эх сурвалжид тулгуурласан онолын харьцуулалт учраас дэвшүүлсэн практик санал, тайлбарыг хүүхдийн бодит орчинд туршин баталгаажуулаагүй болно. Иймд цаашид сургуулийн өмнөх насны хүүхдийн өөртөө чиглэсэн ярианы илрэх давтамж, агуулга, үйл ажиллагааг зохицуулах үүргийг нас, сургалтын нөхцөл, хамтын үйл ажиллагааны хэлбэртэй холбон судлах шаардлагатай. Түүнчлэн Пиаже, Выготский нарын анхдагч бүтээлд тулгуурласан нэр томьёо, онолын тайлбарын харьцуулсан судалгааг өргөжүүлэх нь хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийн талаарх ойлголтыг нарийвчлахад ач холбогдолтой юм.

ДҮГНЭЛТ

Энэхүү онолын харьцуулсан судалгаагаар бага насны хүүхдийн эгоцентр ярианы талаарх Ж.Пиаже, Л.С.Выготский нарын үзэл баримтлалыг үүсэл, мөн чанар, нийгмийн шинж, төрөл, сэтгэл зүйн үүрэг, хөгжлийн чиг хандлага болон судалгааны арга зүйн хүрээнд харьцуулан шинжиллээ. Судалгааны үр дүнд хоёр эрдэмтэн хүүхдийн эгоцентр ярианы үзэгдлийг хүлээн зөвшөөрсөн боловч түүний үүсэл, үүрэг, хөгжлийн чиг хандлагыг ялгаатай тайлбарласан болохыг тодорхойлов.

Ж.Пиаже хүүхдийн эгоцентр яриаг танин мэдэхүйн хөгжлийн онцлог, бусдын байр суурийг харгалзан үзэх чадвартай холбон тайлбарлаж, хүүхдийн өдөр тутмын яриаг байгалийн нөхцөлд ажиглах замаар түүний илрэх хэлбэр, ангиллыг тодорхойлсон байна. Түүний судалгааны арга зүй нь хүүхдийн яриаг насанд хүрэгчдийн ойлголт, тайлбарт шууд захируулахгүйгээр тухайн хүүхдийн үйл ажиллагаа, хөгжлийн онцлогтой нь холбон судлахад чухал ач холбогдолтой юм.

Харин Л.С.Выготский эгоцентр яриаг нийгмийн харилцаанаас үүсэлтэй, хүүхдийн үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулахад оролцдог сэтгэл зүйн хэрэгсэл гэж үзжээ. Тэрээр хүүхдийн үйл ажиллагаанд зориудаар бэрхшээл үүсгэсэн туршилтын нөхцөлд эгоцентр ярианы үүргийг судалснаар уг яриа нь илрэх хэлбэрийн хувьд гадаад боловч гүйцэтгэх үүргийн хувьд дотоод ярианы шинжийг агуулж, цаашид дотоод яриа болон хөгжих боломжтойг тайлбарласан байна.

Ийнхүү хоёр эрдэмтний үзэл баримтлалын гол ялгаа нь хүүхдийн эгоцентр ярианы хөгжлийн чиг хандлага, сэтгэл зүйн үүргийг тайлбарлахад оршиж байна. Гэсэн хэдий ч Пиажегийн ажиглалтын, Выготскийн туршилтын арга зүй нь хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийг өөр өөр талаас судлах боломжийг бүрдүүлсэн бөгөөд тэдгээрийг харьцуулан авч үзэх нь эгоцентр ярианы үзэгдлийг илүү өргөн хүрээнд ойлгоход ач холбогдолтой юм.

Судалгааны үр дүн нь сургуулийн өмнөх боловсролын практикт хүүхдийн өөртөө чиглэсэн яриаг зөвхөн бусадтай харилцах чадварын илрэлээр үнэлэх бус, тухайн хүүхдийн тоглоом, суралцах үйл ажиллагаа, асуудал шийдвэрлэх оролдлоготой холбон ажиглах шаардлагатайг харуулж байна. Иймд багш хүүхдийн өөртөө чиглэсэн яриаг шууд таслан зогсоохоос зайлсхийж, үйл ажиллагаагаа төлөвлөх, бодол санаагаа илэрхийлэх, бусадтай хамтран ажиллах боломжийг дэмжих нь зүйтэй.

Ж.Пиаже, Л.С.Выготский нарын сонгодог судалгаа нь хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжлийг тайлбарлах онолын чухал үндэс хэвээр байна. Цаашид эдгээр үзэл баримтлалд тулгуурлан Монголын сургуулийн өмнөх насны хүүхдийн эгоцентр ярианы илрэл, сэтгэл зүйн үүрэг, хөгжлийн онцлогийг бодит орчинд судлах, багшийн ажиглалт болон сургалтын арга зүйд хэрэглэх боломжийг эмпирик судалгаагаар тодруулах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

Мягмар, О. (2010). *Сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэцийн хөгжлийн зарим асуудал*. Ган Принт.

Мягмар, О. (2016). *Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд*. Ган Принт.

Монгол Улсын Засгийн газар. (2024). *Үзэл баримтлал батлах тухай* (2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоол). https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140353213781

Гадаад хэлээр:

Alderson-Day, B., & Fernyhough, C. (2015). Inner speech: Development, cognitive functions, phenomenology, and neurobiology. *Psychological Bulletin, 141*(5), 931–965. https://doi.org/10.1037/bul0000021

Alharbi, M. O. (2022). Teachers and children's play: Exploring practices through an analysis of Vygotsky and Piaget theories. *The Educational Review, USA, 6*(11), 668–674. https://doi.org/10.26855/er.2022.11.001

Davis, P. E., Meins, E., & Fernyhough, C. (2013). Individual differences in children's private speech: The role of imaginary companions. *Journal of Experimental Child Psychology, 116*(3), 561–571. https://doi.org/10.1016/j.jecp.2013.06.010

Heo, J., Han, S., & Aydin, H. (2011). Piaget's egocentrism and language learning: Language egocentrism (LE) and language differentiation (LD). *Journal of Language Teaching and Research, 2*(4), 733–739. https://doi.org/10.4304/jltr.2.4.733-739

Lourenço, O., & Machado, A. (1996). In defense of Piaget's theory: A reply to 10 common criticisms. *Psychological Review, 103*(1), 143–164. https://doi.org/10.1037/0033-295X.103.1.143

Piaget, J. (1926). *The language and thought of the child*. Kegan Paul, Trench, Trubner & Co.

Veraksa, N., & Pramling Samuelsson, I. (2022). Piaget and Vygotsky in XXI century: Discourse in early childhood education. In *Early childhood research and education: An inter-theoretical focus* (pp. 7–27). Springer. https://doi.org/10.1007/978-3-031-05747-2

Zhao, Y. (2022). A study of preschool children's second language acquisition from the perspective of Piaget's theory of cognitive development stages: A comparison between Raz and Oxford Reading Tree. *Advances in Social Science, Education and Humanities Research, 451*, 657–665.

Выготский, Л. С. (1934). *Мышление и речь: Психологические исследования*. Государственное социально-экономическое издательство.

Жан Пиаже. (2010). *Теория, эксперименты, дискуссы*. Гадарики.

Кравец, А. С. (2015). Трудный путь к истине: Л. С. Выготский против Ж. Пиаже в трактовке онтогенеза детской речи. *Вестник ВГУ. Серия: Философия*, (4), 17-57.

Пашукова, Л. (2016). Концептуальные отличия в понимании эгоцентризма детского мышления и речи Ж. Пиаже и Л. С. Выготским. *Вестник Московского государственного лингвистического университета. Образование и педагогические науки*, 104-118.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс, санаа: О.М; Арга зүй: О.М, Б.Б; **Мэдээлэл цуглуулалт:** О.М, Б.Н; **Бичилт (эхний хувилбар):** О.М, О.М**; Бичилт (засвар):** О.М, О.М, Б.Н; **Санхүүжилт:** Д.Д; **Нөөц:** Б.Н; **Мэргэжлийн удирдлага:** О.М

ЗОХИОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

Овог, нэр: Очиржав Мягмар
https://orcid.org/0009-0005-6888-9859
Байгууллагын нэр: МУБИС
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө, МУБИС-ийн 8 байр, Улаанбаатар 14191
Улс: Монгол
e-mail: myagmar1125@gmail.com

Овог, нэр: Одонхүү Мөнхжаргал
https://orcid.org/0009-0002-1526-9451
Байгууллагын нэр: МУИС (Баруун Бүсийн сургууль)
Хаяг: Ховд аймаг, Жаргалант сум, Жаргалан баг, Хичээлийн I байр
Улс: Монгол
e-mail: munkhjargalo@num.edu.mn